



АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ДЭЭД ШҮҮХ (ЭРҮҮГИЙН ХЭРЭГ¹)

ЦАХИМ ОРЧИНД БУСДЫГ ЗАНАЛХИЙЛСЭН ЗАХИДАЛ ИЛГЭЭСЭН БОЛ ШҮҮГДЭГЧИЙН СЭДЛЭЭС ҮЛ ХАМААРАН ГЭМ БУРУУТАЙД ТООЦНО

Каунтерман в. Колорадо

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын хяналтын шатны шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн нэр: Counterman v. Colorado, 600 U.S. 66 (2023)

Шүүхийн шийдвэрийн дугаар: Дугаар 22-138

Шүүхийн шийдвэрийн огноо: 2023 оны 06 сарын 27-ны өдөр

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч Билли Рэймонд Каунтерман нь 2014 онд олны танил дуучин эмэгтэй хохирогч руу Фейсбүүкээр удаа дараа холбогдсон ба хохирогч түүнийг блоклон дахин холбогдох боломжгүй болгожээ. Гэсэн ч шүүгдэгч хохирогчийг нууцаар ажиглаж, өөр өөр хаягаас хохирогчийн үхэл болон, түүнийг хөнөөхийг хүсэж байгаа тухай заналхийлсэн агуулга бүхий мессеж илгээж байжээ. Хохирогч шүүгдэгч Каунтерманыг хууль сахиулах байгууллагад мэдэгдсэн бөгөөд шүүгдэгчийг бусдыг мөрдсөн (энэ нь заналхийлэлд тооцогдоно), бусдад сэтгэл санааны хүнд дарамт учруулсан төдийгүй танхайрсан хэргээр 2016 онд баривчилсан байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Шүүгдэгч тус Фейсбүүкийн мессежнүүд нь жинхэнэ заналхийлэл биш бөгөөд түүнийг гэм буруутайд тооцож яллах нь АНУ-ын Үндсэн хуулийн Нэгдүгээр заалтын дагуу үг, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг нь зөрчиж байна хэмээн

¹ Эх сурвалж: <https://www.oyez.org/cases/2022/22-138>

Хураангуйг орчуулахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.

Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://www.supremecourt.gov/opinions/22pdf/22-138_43j7.pdf



маргажээ. Анхан шатны шүүх түүний хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, тангарагтны шүүх түүнийг бусдыг мөрдсөн, бусдад сэтгэл санааны хүнд дарамт учруулсан гэм буруутайд тооцсон бөгөөд Колорадогийн давж заалдах шатны шүүх мөн түүний гомдлыг хэрэгсэхгүйд тооцож, түүнд оногдуулсан ялыг хэвээр үлдээв.

АНУ-ын Дээд шүүх шүүгдэгчийн гомдлыг хүлээн авч хэргийг хянан шийдвэрлэсэн ба нийт шүүгчдийн олонхын санал буюу 7-2 саналаар шийдвэр гарган “АНУ-ын Үндсэн хуулийн Нэгдүгээр заалтаар хамгаалагдах үг, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхэнд үл хамаарах бусдыг заналхийлэх үйлдлийг шүүгдэгч үйлдсэн эсэхийг тогтоох үед тухайн этгээд өөрийн үйлдлээ субъектив талаас заналхийлсэн утга агуулгатайг мэдэж байсан байх шаардлагатай бөгөөд тус этгээдийн занал хийх санаа, сэдэл байхгүй байсан эсэхээс үл хамаарна” хэмээн шийдвэр гаргасан байна.

Мөн түүнчлэн, шүүгдэгчийн өөрийн бодол, санаа, сэдлээс үл хамааран тухайн үйлдэл нь бусдыг заналхийлсэн эсэх талаар объектив талаас нь дүгнэх бөгөөд шүүгдэгч хайхрамжгүйгээр тус үйлдлийг хийсэн байх төдийд л гэмт буруутайд тооцогдоно гэж үзжээ.

Орчуулсан: Э. Төгөлдөр

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн

Эрүүгийн эрх зүйн судлаач